

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Улсын аварга тариаланч хамт олон”, “Улсын аварга тариаланч”-ийн шагналын дурсгалын цом нийт 33 ширхэгийг 22,440,000.00 (Хорин хоёр сая дөрвөн зуун дөчин мянга) төгрөгийн төсөвт өртөгт багтаан үйлдвэрлэн нийлүүлэх тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.
2. Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон тендерийн баримт бичгийг ХХААХҮЯ-ны 503 тоот өрөөнөөс ирж авна уу.
3. Үнийн саналыг **2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын 503 тоот өрөөнд** ирүүлнэ.
4. Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2021 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 10 цаг 30 минутанд** нээнэ.

*Захиалагчийн хаяг:*

*Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайваны өргөн чөлөө 16А, Засгийн газрын 9 дүгээр байр,  
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 505 тоот өрөө.  
Утас: 263408, факс: 263237*